

*Далайн захиргааны 2014 оны
үйл ажиллагааны тайлан*




2014-2015



Mongolia Maritime Administration

2014-2015




Далайд гарцгүй хөгжиж буй орнуудын Олон улсын судалгааны төвтэй хамтран ажиллах санамж бичигт 2014 оны 1 дүгээр сард гарын үсэг зурав.




Монгол-Солонгосын Далайн тээврийн хамтарсан компанийг 1 дүгээр сарын сарын 9-ний өдөр байгуулсан.

Монгол Улсын Зам, тээврийн яам, БНСУ-ын Газар, тээвэр, далайн хэргийн яамны далайн салбарын асуудлаарх ээлжит 5 дугаар хуралдаан энэхүү өдөр хуралдаж БНСУ-ын Далайн хэрэг, загас агнуурын яамны дэд сайд Жон Ки Жонг далайн тээврийн хамтарсан компани байгуулах гэрээнд гарын үзэг зурах үйл ажиллагаанд оролцож, хамтран ажиллах протоколд гарын үсэг зурсан.



Шинэчлэлийн Засгийн газар яам, агентлагуудын үйл ажиллагааг сурталчлах, иргэдэд хүрч ажиллах зорилгын хүрээнд 2014 оны 5 дугаар сарын 18-нд Зам тээврийн яам болон яамны харьяа газрууд ажлаа танилцуулах нээлттэй хаалганы өдрийг зохион байгуулсан.



Гадаад Харилцааны яам, Далайд гарцгүй хөгжиж буй орнуудын Олон улсын судлагааны төв болон UNCTAD, Дэлхийн худалдааны байгууллага WTO, Дэлхийн банк, UNDP хамтран Улаанбаатар хотноо 2014 оны 6 дугаар сарын 1, 2-ны өдрүүдэд зохион байгуулсан Дэлхийн Худалдааны байгууллагын “Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээр”-ийн хүрээнд зохион байгуулагдсан “Далайд гарцгүй хөгжиж буй орнуудад үзүүлэх нөлөөлөл” сэдэвт олон улсын хуралд амжилттай оролцсон.



Далайн захиргаа, Далайд гарцгүй хөгжиж буй орнуудын судлагааны төв хамтран “Далайн эрх зүй ба далайд гарцгүй хөгжиж буй орнуудын эрх ашиг” хэмээх леки хэлэлцүүлэгт Далианы Далайн Их сургуулийн Хуулийн профессор, лектор Прошанто К. Мукержийг урьж авчран 2014 оны 06 дугаар сарын 17-ноос 06 дугаар сарын 19-ний хооронд Улаанбаатар хотноо амжилттай зохион байгууллаа.



Хөвсгөл аймгийн Хатгал тосгонд усан замын тээврийн хэрэгслээр үйл ажиллагаа явуулж буй иргэн, аж ахуй нэгж, байгууллагын усан замын тээврийн хэрэгслийн эзэд, тээврийн хэрэгслийг жолоодож буй иргэдэд урьдчилан зарласан хугацааны дагуу 2014 оны 6 дугаар сарын 29-ний өдөр усан замын тээврийн хэрэгслийн аюулгүй үйл ажиллагааны нэгдсэн хурлыг нутгийн удирдлагуудтай хамтран зохион байгуулсан.



Усан замын тэмдэг тэмдэглэгээ байрлуулах ажлыг 7 дугаар сарын 10-наас 7 дугаар сарын 13-ний хооронд зохион байгуулсан.



БОНХЯ-ны Хөвсгөл нуур, Эгийн голын сав газрын захиргаа, ССАЖЯ-ны Аялал жуулчлалын үндэсний төв, Хөвсгөл аймгийн ОБХ-тэй хамтран усан замын тээврийн хэрэгслийг жолоодогч нарт зориулан анхан болон давтан сургалтыг 2014 оны 7 дугаар сарын 21-нээс 7 дугаар сарын 23-ны хооронд зохион байгуулсан. Мөн усан замын тээврийн хэрэгсэлийн техник жолоогийн үзлэг, хяналт, шалгалтыг ЗТЯ, МХЕГ-тэй хамтран зохион байгуулсан.



Усан замын тэмдэг тэмдэглэгээ байрлуулах ажлыг 7 дугаар сарын 10-наас 7 дугаар сарын 13-ний хооронд зохион байгуулсан.



БОНХЯ-ны Хөвсгөл нуур, Эгийн голын сав газрын захиргаа, ССАЖЯ-ны Аялал жуулчлалын үндэсний төв, Хөвсгөл аймгийн ОБХ-тэй хамтран усан замын тээврийн хэрэгсэл жолоодогч нарт зориулан анхан болон давтан сургалтыг 2014 оны 7 дугаар сарын 21-нээс 7 дугаар сарын 23-ны хооронд зохион байгуулсан. Мөн усан замын тээврийн хэрэгслүүдийн техник экологийн үзлэг, хяналт, шалгалтыг ЗТЯ, МХЕГ-тай хамтран зохион байгуулсан.





ОХУ болон БНАСАУ-ын хамтарсан РасонКонТранс компанийн Ерөнхий захирал Олег Вадимович Агафонцевийг Улаанбаатар хотноо урьж 2014 оны 8 дугаар сарын 23-наас 8 дугаар сарын 27-ны өдөр далайн боомт хамтран ашиглах талаар уулзалтыг амжилттай зохион байгууллаа.



ГЕНЕРАЛЬНЫЙ ДИРЕКТОР СП «РАССОНКОНТРАНС» ОЛЕГ АГАФОНЦЕВ

2014 оны 9 дүгээр сарын 25, 26-ны өдрүүдэд БНХАУ-ын Рижао хотын дэд дарга Лью Шилян, Рижао боомтын ерөнхий менежер Мин Жаншан, Рижао хотын худалдааны товчооны захирал Ли Ийдон нартай уулзаж Монгол Улсын далайд гарах боломжийг нэмэгдүүлэх, БНХАУ-ын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх, шинээр баригдаж буй төмөр зам, боомт ашиглах зэрэг санал дэвшүүлэн санамж бичиг байгуулах, яриа хэлэлцээр хийхэд бэлэн байна гэдгээ БНХАУ-ын зүгээс илэрхийлсэн.



“ХУВИЙН ХӨВӨГЧ ХЭРЭГСЭЛ - 4-р хэсэг: Аврах хантааз, үзүүлэлтийн түвшин-100, Аюулгүй үйл ажиллагааны шаардлагууд, MNS ISO 12402-4:2014 стандартыг Стандартчиллын үндэсний зөвлөлийн хурлаар 2014 оны 10 дугаар сарын 03-ны өдөр хэлэлцүүлж батлуулсан.



МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Хувийн хөвөгч хэрэгсэл, 4-р хэсэг:
Аврах хантааз, гүйцэтгэлийн түвшин-100
Аюулгүй ажиллагааны шаардлагууд



Албан хэвлэл

СТАНДАРТЧИЛАЛ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР
Улаанбаатар хот
2014 он

Аврах ажиллагааны тухай 1989 оны Лондонгийн конвенцид нэгдэн орох тухай болон Далайн хөдөлмөрийн тухай Олон Улсын хөдөлмөрийн байгууллагын 2006 оны конвенцид нэгдэн орох тухай хуулийг 2014 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр УИХ-ын чуулганаар хэлэлцүүлж батлуулсан.

The screenshot shows the Mongolian legal system website. At the top, there is a navigation bar with the following items: НҮҮР ХУУДАС, ЭРХ ЗҮЙН АКТ, МЭДЭЭ, СУРГАЛТ, МЭДЛЭГИЙН САН, БАЙГУУЛЛАГА, НОМ, and ТУСЛАМЖ. Below the navigation bar, the breadcrumb trail reads: Үндсэн нүүр > Монгол Улсын олон улсын гэрээ > ДАЛАЙН ХӨДӨЛМӨРИЙН ТУХАЙ КОНВЕНЦИД НЭГДЭН ОРОХ ТУХАЙ. There are two buttons: Хууль зүйн акт and Жаргасалтруу Буцах. Below the buttons are icons for printing, PDF, and a minus sign. The main content area is titled МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ and includes the date 2014 оны 11 сарын 21 өдөр and the location Төрийн ордон, Улаанбаатар хот. The title of the law is ДАЛАЙН ХӨДӨЛМӨРИЙН ТУХАЙ КОНВЕНЦИД НЭГДЭН ОРОХ ТУХАЙ. The text of the law is: 1 дүгээр зүйл. Далайн хөдөлмөрийн тухай Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 2006 оны конвенцид Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр нэгдэн орсугай. Below the text, the signatories are listed: МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА and 3.ЭНХБОЛД. The same structure is repeated for the second law, titled АВРАХ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ КОНВЕНЦИД НЭГДЭН ОРОХ ТУХАЙ, with the text: 1 дүгээр зүйл. Аврах ажиллагааны тухай 1989 оны Лондонгийн конвенцид Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр нэгдэн орсугай. The signatories are also listed as МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА and 3.ЭНХБОЛД.

БНХАУ-ЫН БООМТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ ТАНИЛЦАВ.

Монгол Улсын Далайн захиргааны мэргэжилтнүүд 2014 оны 11 дүгээр сарын 9-ний өдрөөс 18-ны өдрүүдэд БНХАУ-ын Тяньжин, Сао Фэй Диан болон Рижао гэсэн боомтуудын үйл ажиллагаатай танилцлаа.



Монгол Улсад анх удаа Олон улсын далайн байгууллагын үндэсний сургалт, зөвлөгөөн 12 дугаар сарын 15-19-ний хооронд Улаанбаатар хотноо зохион байгуулагдлаа. Энэхүү сургалт зөвлөгөөнд Зам, тээврийн сайд Н.Төмөрхүү, НҮБ-ын Монгол дахь Суурин төлөөлөгч Сезин Синаноглу, Олон улсын далайн байгууллагын зөвлөх аудитор Моин Ахмед, Лесли Хемачандра нар оролцсон юм.





*Анхаарал хандуулсанд
баярлалаа*